

СТАНДАРТ,ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
5 ДУГААР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГТ ХИЙСЭН АЖИЛ

- Тус хэлтсийн бүх ажилтнууд 05 дугаар сарын 01- ний өдөр Онцгой байдлаас зохион байгуулсан онцгой комисс,орон нутгийн гамшгаас хамгаалах алба,мэргэжлийн ангийн штабын сургалт,дадлагад оролцов.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Байгаль хамгаалах сарын аян” зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжийн дагуу тус хэлтэс нь 2017 оны 04 дугаар сарын 28-ны өдөр Өлгий сумаас Хотгор нүүрсний Уурхайд гарах зам дагуу хуваарьтай газарт их цэвэрлэгээ хийж гүйцэтгэв. Хэлтсийн бүх ажилтнууд идвэхтэй оролцож 15 шуудай хатуу хог түүж, зарим хогуудыг шатааж устгав.Цэвэрлэгээ хийсэн тухай тайланг Өлгий сумын хот тохижуулах албанд хүргүүлэв.
- “Скифсак” ХХК-ны Казакстан улсаас оруулж ирсэн согтууруулах ундаанд баталгаажуулалт хийж тохирлын гэрчилгээ олгов.
- Өлгий сумын 1, 2, 3,12,13-р багуудын хүнсний дэлгүүрүүдэд худалдаа,үйлчилгээний газруудын хүнсний аюулгүй байдал стандартын хэрэгжилт ЗГазрын 127 тогтоолын биелэлтэнд хяналт хийж 35 хүнсний дэлгүүрийг хяналтанд хамааруулав. Мөн худалдаа, үйлчилгээний газруудын ашиглаж байгаа нийт 35 ш механик хэмжих хэрэгсэлд ээлжит баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгов.

СТАНДАРТ,ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС